




10 сарын тайлан



Витаминаа уугаад хоолоо сайн идээд өссөөр л

Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч нар өдөр тутамдаа
витаминаа уугаад хоолоо сайн идээд өссөөр л.
Үйлчлүүлэгч нар маань том багагүй л таргалчихлаа
гэдэг сэдэв ихээр хөндөн суудаг болж. Туранхай
нэгнийгээ харж чам шиг болох юмсан гэж ярьж. Багш
нартаа би тэдэн килограмм нэмлээ арай
ч дээ тэдэн сар, хоног дотор хэмээн тэр
үед нь бүгд л ашгүй дээ, өө сайн байна
гэхээр юу вэ багшаа яаж турах вэ гэж
байхад чинь гээл гомдорхон хэлээд
бөөндөө инээлдэн суудаг боллоо.





Догь зогсоод вакцинаа хийлгэв

Хамгийн бяцхан үйлчлүүлэгч маань ч вакциндаа хамрагдахаар очив. Эмнэлэгт очерлох хооронд юм оролдоод энэ тэнд яваад байхаар нь за чи куртик бариад энд томоотой зогсоод байж байгаарай гэтэл за гээл 2 минут их л догь зогсоод үймээндээ оров.



Бага насны үйлчлүүлэгч нарын ар гэрээс бичгэн хэлбэрээр зөвшөөрөл авч томуугийн вакцинд хамрууллаа.



Өгөөний үс самналт



Цэцэрлэгийн 2 маань өглөө хамгийн түрүүн босож гарах бэлтгэлээ хийнэ. Өглөө босоол хувцас өмсөх, нүүр гар шүдээ угаах, үсээ самнуулах гээл хажуугаар нь өрөө өрөө хэсээд багшдаа олдохгүй явж өгнө. Ер нь манай 2 өглөөд гартлаа завгүй хийх юм ихтэй ихтэй.

Зарим өглөө их л залхуу нь хөдөлдөг болтой нам гүм энд тэнд сууж байдаг юм. Яг тэр залхуутай өглөө нэг иймэрхүү.



Halloween

Үйлчлүүлэгч хүүхдүүд маань Halloween-ий баярт оролцож хайртай, дуртай үлгэрийн баатрынхаа дүрд хувирав. Ид шидийн орон 2 төв дээр зохион байгуулагдсан тус үйл ажиллагаанд хамгаалах байрны нийт хүүхдүүд оролцож цагийг хөгжилтэй өнгөрүүлэв



Ууланд алхалт

Эрүүл мэнд, дархлаагаа дэмжих зорилгоор Богд- Уулын алхалт хийж цэвэр агаарт хөгжилдөн дурсамжтай мөчийг хамтдаа өнгөрүүлэв. 7 настай үйлчлүүлэгч хүү:



Багшаа ууланд гарах үнэхээр гоё байна тээ. Тэр хойно явж байгаа багш нар маань өндөр настай болохоор хэцүү байх шиг байна, бид нар залуу хүүхдүүд болохоор хурдан алхаж байна тэ? гэж асуув.



10 сарын 11-ний өдөр хамгаалах байрны 1 үйлчлүүлэгчээс ковид цар тахлын батлагдсан тохиолдол илэрсэн бөгөөд багш ажилтнууд, үйлчлүүлэчийг тусгаарлаж эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж үйлчлүүлэгч эдгэсэн учир түр хамгаалах байр эргэн хэвийн нөхцөлд ажиллаж байна.

Нийт үйлчлүүлэгчдийн дархлааг дэмжиж, витаминжуулалт хийв.



2021.10.31

Ид шидийн орон ХХХТ-н ТҮР ХАМГААЛАХ БАЙРАНД



НИЙТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

12

ХҮЛЭЭН АВСАН
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД

+1

Хүйс



Эмэгтэй

8



Эрэгтэй

4

Нас



1-5 нас

2



6-10 нас

4



11-16 нас

6

Тайлбар:

Ид шидийн орон ХХХТ-н түр хамгаалах байранд 10 сарын 31-ны байдлаар 12 үйлчлүүлэгч хамгааллын үйлчилгээг авч байна. Үйлчлүүлэгчдийн 8 эмэгтэй, 4 эрэгтэй. 1-5 насны 2 үйлчлүүлэгч, 6-10 насны 4 үйлчлүүлэгч, 11-16 насны 6 үйлчлүүлэгч байна. 10-р сард 1 үйлчлүүлэгчийг шинээр хүлээн авсан. Хамгийн бага насны үйлчлүүлэгч 3 настай.



Үйлчлүүлэгчид маань цахим, танхимийн хичээлүүддээ бүрэн хамрагдаж, нэмэлт давтлага, хичээлийн хоцрогдол арилгах сургалтанд хамрагдаж номын сангаар үйлчлүүлж байна.



Санхүүгийн тайлан

ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ
Цэцэрлэг хамгаалах байрны хүүхдийн хоолны зардал
Цэцэрлэгийн хангамжийн зардал
Сургалт, судалгаа, хөгжүүлэлтийн хэрэглэгдэхүүний зардал

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ
Хамгаалах байрны хүүхдийн хоолны зардал
Хамгаалах байрны хүүхдийн хувцас зардал
Хамгаалах байрны хүүхдийн ахуйн хэрэглэлийн зардал
Сэтгэл заслын үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын нийгэмшүүлэх үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрүүл мэнд эм хангамж зардал
Хүү хам үйлчилгээний хангамж зардал/ үс замах анги цэвэрлэгэ хуримтлал
Бичиг хэргийн зардал
Томилолтын зардал
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал

АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ

Цахилгаан
Бохир ус
Цэвэр ус
Хог тээвэр
Интернет
Утас ид шидийн орон
Утас хамгаалах байр
Хангамжийн зардалд

ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

Цалингийн зардал /хамгаалах байр /
Цалингийн зардал /Ид шидийн орон нэг /
НДШ-ийн зардал /нийт цалин/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Маркетингийн зардал
Ногоон байгууламжийн арчилгааны зардал
Цэвэрлэгээ, ариутгалын зардал
Засварын зардал
Тоног төхөөрөмжийн засварын зардал
Тоног төхөөрөмж
Шатахууны зардал
Түрээс
Тээврийн зардал
Шатахууны зардал ид шидийг орон нэг
Тээврийн зардал ид шидийн орон нэг
харуул хамгаалалтын зардалд
Томилолтын зардал ид шидийн орон нэг
Бичиг хэргийн зардал ид шидийн орон нэг
Сургалтын зардал
Татварын зардал Үл хөдлөх, газар машин үзлэг
Даатгалын зардал

Үйл ажиллагааны зардал
2,153,400.00₮

Хүүхэд хөгжлийн хөтөлбөрийн зардал
1,614,140.00₮

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зардал
787,100₮

Цалингийн зардал
16,766,468.56₮



Ашиглалтын зардал
359,390.00₮

Хүүхэд бүхэн инээнэ
Ид шидийг бүтээнэ...

